# ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ИРҮҮЛЭХ ЗААВАР

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

## Мастерфайл татаж авах



1. WWW.FRC.MN

2. ЦАХИМ ТАЙЛАН

3. МАСТЕР ФАЙЛААР ИЛГЭЭХ

УЛИРЛЫН ТАЙЛАН



# ТАЙЛАН, МЭДЭЭНИЙ МАСТЕРФАЙЛЫГ АШИГЛАХ



## Мастерфайл татаж авах

ХЗХ-д улирал бүрийн санхүүгийн тайланг дараа сарын 10-ны өдрийн дотор цахимаар болон цаасаар Хороонд ирүүлэх үүрэгтэй бөгөөд тайланг илгээхдээ улирал бүр мастерфайлыг шинээр татан авч илгээнэ.






# ТАЙЛАН, МЭДЭЭНИЙ МАСТЕРФАЙЛЫГ АШИГЛАХ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

## Тайланд анхаарах зүйлс



1. Тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаатай холбогдох дансанд бичилт хийхгүй байх;
2. Файлын төрөл MS EXCEL 97-2003 байх;
3. Санхүүгийн тайланг илгээхдээ улирал бүр www.frc.mn цахим хаягаас мастерфайлыг шинээр татан авч илгээх;
4. STATISTICS тайлангийн Хадгаламж, зээлийн хоршооны нэр хэсэгт ХЗХ-ны нэрийг нөхөх;
5. Тайлангуудыг зөв, бүрэн нөхөхөд "Утга нөхөх“, “Алдаатай”, “Зөрүүтэй” гэсэн алдаа арилна. "Утга нөхөх“, “Алдаатай”, “Зөрүүтэй” алдаатай тайланг Фин-А систем хүлээн авахгүй болно.
6. Мастерфайлыг нэрлэхдээ SCCNXXXXXXXq022021 буюу зөвхөн XXXXXXX-ын оронд регистрийн дугаарыг, q-ын ард тухайн тайлант улирлын тоог оруулан нэрлэнэ. Жишээ: SCCN1234567q022021.

## Мастерфайлд гараас утга оруулахдаа анхаарах зүйлс



1. Нүдэнд (cell) утга оруулахдаа аливаа бодолт хийж болохгүй, зөвхөн гараас анхны утга оруулах;
2. Copy, Paste хийхдээ “values” буюу томъёогүй форматаар оруулна. Мөн оруулахдаа багана тус бүрээр оруулах;
3. Тайланд сөрөг утгатай дүн оруулахгүй;
4. Нүдэнд оруулах тоон утгын нарийвчлал нь зуу (0.99)-ны нарийвчлалаас хэтрэхгүй. Жишээ: зөв 150,375.23 | буруу 150,375.234, 150,375.2
5. Хадгаламжийн болон зээлийн хүүг аравт, зуутын орноор бичих. Жишээ нь: гурав аравны хоёр хувийн хүүтэй бол зөв 3.2% | буруу 0.32%, 0.032%

# ТАЙЛАН, МЭДЭЭНИЙ МАСТЕРФАЙЛЫГ АШИГЛАХ



## Тайланд гараас утга оруулахдаа анхаарах зүйлс



1. Зээл олголт болон хадгаламжийн хүүгийн судалгааны тайлан эхний үлдэгдэл дүн зөвхөн өмнөх оны жилийн эцсийн дүн тавигдана /улирал бүр/.
2. Статистик мэдээллийг нөхөхдөө гишүүдийн насжилт, боловсролын тоог нийт гишүүдийн тооноос хуулийн этгээдийн тоог хасаж, үнэн зөв бөглөх;
3. Статистик мэдээлэлд зээлдэгчдийн насжилт, боловсролын тоог нийт зээлдэгчийн тооноос хуулийн этгээдийн тоог хасаж бичих;
4. Статистик мэдээлэлд хадгаламж эзэмшигчдийн насжилт, боловсролын тоог нийт хадгаламж эзэмшигчийн тооноос хуулийн этгээдийн тоог хасаж бичих;
5. 40 том зээлдэгчид олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад хөрөнгийн тайлан, Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад хөрөнгийн тайлан, 40 том хадгаламж эзэмшигчийн тайланг шивэхдээ ажил эрхлэлт, зээлийн зориулалт, барьцаа хөрөнгийн төрөл, хөрөнгийн ангилал, хадгаламжийн төрөл зэрэг сонголттой утгуудыг заавал гараас сонгож оруулна. Өмнөх файлаас Copy, Paste хийсэн тохиолдолд тайланд алдаа заана.

# ВЭБЭЭР ИЛГЭЭХ

Фин-А системд Санхүүгийн зохицуулах хорооны www.frc.mn цахим хуудас дахь Цахим тайлан хэсгийн Вэбээр илгээх https://dcs.frc.mn:8443/dcs цэсээр хандаж тайлангаа илгээнэ.







**Хэрэглэгчийн нэр:**

ХЗХ-ны регистрийн дугаар

**Нууц үг:**

Хорооны мэдээлэл технологийн хэлтсээс өгсөн нууц үг



**Нууц үгийг солихыг анхаарна уу.**

# ВЭБЭЭР ИЛГЭЭХ







